

**“СТАНДАРТ ПРОПЕРТИ ГРУПП” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2024 оны 2 сарын 21 өдөр

Дугаар \_\_\_

Улаанбаатар хот

**Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай**

“СТАНДАРТ ПРОПЕРТИ ГРУПП” ХК –ийн 2024 оны 3-р сарын 21–ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын хоёрдугаар тэмдэглэлийг үндэслэн **ТОГТООХ нь:**

**Нэг.** “Стандарт проперти групп” ХК –ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 4-р сарын 30–ны өдөр 10:00 цагт, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын гудамж, 5/3 тоот Стандарт Финаншл Групп Оффисын хоёрдугаар давхарын хурлыг хуралдуулсугай. Хурлыг ТУЗ –ийн дарга Г.Хатанболд даргалсугай.

**Хоёр.** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 4-р сарын 10-ны өдрөөр тогтоож, “Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл” –ийг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид 2024 оны 3-р сарын 21–ны өдөр хүргүүлэн, хурлын товыг Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам” –ын дагуу 2024 оны 3-р сарын 22–ны өдөр олон нийтэд зарласугай.

**Гурав.** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичгийг 2024 оны 3-р сарын 31–ний өдрийн дотор брокер дилерийн компаниудад хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүргүүлэхээр тогтоосугай.

**Дөрөв.** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлуудыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

**Тав.** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох бичиг баримтуудын жагсаалт, уг бичиг баримтуудтай танилцаж болох газар, хугацааг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

**Зургаа.** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг гуравдугаар хавсралтаар баталсугай.

**Долоо.** Хурлын өдөр ирсэн хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар санал авахаас гадна брокер дилерийн компаниар дамжуулан урьдчилан санал авах сүүлчийн өдрийг 2024 оны 4-р сарын 30–ны өдрөөр тогтоож, санал авах хуудасны агуулга, загварыг дөрөвдүгээр хавсралтаар баталсугай.

**Найм.** Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах хэвлэлийн эхийг тавдугаар хавсралтаар баталсугай.

**“СТАНДАРТ ПРОПЕРТИ ГРУПП” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2024 оны 3 сарын 21 өдөр

Дугаар \_\_\_


Улаанбаатар хот

**Ес.** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, хурлыг зохион байгуулах, хэлэлцэх асуудлын бэлтгэлийг хангаж ажиллахыг даалгасугуй.

Зохион байгуулах комиссын дарга:  Б.Хуяг

Гишүүн:  Н.Баярсайхан

**Арав.** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилж, даалгах ажлыг 6 дугаар хавсралтаар баталсугай.

Тооллогын комиссын дарга:  Ө.Пагваа

Гишүүд:  Ч.Дэлгэрсайхан

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:

 /Т.ХАТАНБОЛД/  
  
СТАНДАРТ ПРОПЕРТИ ГРУПП ХК  
STANDARD  
PROPERTY GROUP  
JSC  
УЛААНБААТАР ХОТ  
11152086 /т.х. 2010054